| Арга хэмжээ | 1.1 | Татварын бааз суурийн судалгааг гаргаж төсвийн орлогын төлөвлөлтийг хийх. | - | Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 11429620.3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 12671200.7 мянган төгрөг төвлөрч 110 хувийн гүйцэтгэлтэй байна. 1. Улсын төсвийн орлого 1712938.1 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 2112588.7 мянган төгрөг төвлөрч 123,3 хувь 2. Аймгийн төсвийн орлого 1467253.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 1542314.9 мянган төгрөг төвлөрч 105,1 хувь 3. Сумын төсвийн орлого 8249429.2 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 9016297.1 мянган төгрөг төвлөрч 109,3 хувь | 100 |
| | 1.2 | Татвар төлөгчийн төрлийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | - | Татвар төлөгчийн тоо | 43505 | 44500 | Татвар төлөгчийн баазыг 5,6 хувиар нэмэгдүүлж татвар төлөгчийн тоо татварын төрлөөр нийтдээ 45957 байна. | 100 |
| Зорилт | 2 | Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулах | ОНТ 0.5 | Тайлан тушаалтын дундаж хувь | 80 | 90 | Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг 93.1% хувьтай нэгтгэгдэж Сангийн яаманд хүргүүллээ. | 100 |
| Арга хэмжээ | 2.1 | Аймгийн аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэлийн стандартыг нэвтрүүлэн санхүүгийн тайлан тушаалтын хувийг нэмэгдүүлэх. | | Тайлан тушаасан ААН-ийн тоо | 643 | 663 | Аж ахуйн нэгж байгууллагын 2021 оны жилийн тайлангаар 693 аж ахуй нэгж байгууллагын тайланг нэгтгэж тайлан гаргалт 93,0 хувьтай нэгтгэгдлээ. | 100 |
| | 2.2 | Аж ахуйн нэгж | ОНТ | Аж ахуйн | 10 | 13 | "Хүний хөгжлийг дэмжих" жилийн хүрээнд бизнес | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|--|-----|--|---------|---|----|----|--|-----|
| | | байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хууль эрх зүй, бүртгэлийн бодлогын талаар сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулах. | 0.5 | нэгжийн сургалтад хамрагдалтын хувь | | | эрхлэгчид болон татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжийг сурталчлах, Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргахтай холбоотой заавар зөвлөгөө өгөх, төрийн бодлого шийдвэрийг танилцуулах, бизнес эрхлэгчдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор “БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ” сургалт хэлэлцүүлгийг “Татварын мэргэшсэн зөвлөх нийгэмлэгийн Дундговь салбар”, “Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Дундговь салбар”-тай хамтран танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгууллаа. Уг сургалт хэлэлцүүлэгт танхимаар 64-н ААНБ, цахимаар 73 ААНБ хамрагдсан байна. | |
| ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС | | | | | | | | |
| Зорилт | 1 | Захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлнэ. | ОНТ 4.5 | Сум, агентлагийн үнэлгээний дундаж хувь | 83 | 84 | Захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг 84,9 хувьтай байгаа нь өмнөх оноос 1,9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 100 |
| Арга хэмжээ | 1.1 | Сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх | ОНТ 2.0 | Үнэлгээнд хамрагдсан сумын тоо | 15 | 15 | Аймгийн 15 сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг удирдамж аргачлалын дагуу ажлын хэсэг байгуулан үнэлж, үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, тэргүүлсэн 2 сумын Засаг даргыг шагнаж урамшууллаа. | 100 |
| | 1.2 | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх | ОНТ 2.5 | Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 22 | 22 | Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23 хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг удирдамж аргачлалын дагуу үнэлж, үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан тэргүүлсэн 3 байгууллагыг шагнаж урамшууллаа. | 100 |
| | 1.3 | Явцын хяналт шинжилгээг сум, агентлагуудад удирдамжийн дагуу хийх | - | Явцын хяналт шинжилгээнд хамрагдсан сум, байгууллагын тоо | 37 | 39 | Явцын хяналт шинжилгээ хийх удирдамж боловсруулан батлуулж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын 24 агентлаг, 15 сумдад явцын хяналт шинжилгээг хийж, бодлогын баримт бичиг болон байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөн тусаллаа. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|---------------------------------|-----|---|----------|--------------------------------------|------|------|---|-----|
| | 1.4 | Сум, агентлагт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга зүйгээр хангах | - | Хамрагдсан сум, байгууллагын тоо | 37 | 37 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс агентлагийн хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтнүүд болон сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, нийгмийн бодлогын мэргэжилтэн нарын сургалтын үеэр 2021 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дүнг танилцуулан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн зөвлөгөөг өгснөөс гадна Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 газар, хэлтэс агентлаг, 15 сумын Засаг даргын Тамгын газарт явцын хяналт шинжилгээг хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцтай танилцан албан хаагчдыг арга зүйгээр хангасан. | 100 |
| | 1.5 | Төрийн албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах, төлөвлөх, тайлагнах чиглэлээр чадавхжуулах сургалтыг зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо | 5 | 6 | Бодлогын баримт бичиг болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журамд орсон өөрчлөлт, төлөвлөлт ба хяналт шинжилгээ, үнэлгээний уялдаа холбоо, тайлагналтад анхаарах асуудал зэрэг сэдвээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, агентлагуудын төлөвлөлт хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан албан хаагчид, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд болон Соёл урлагийн газрын харьяа байгууллагын албан хаагчдад, мөн явцын хяналт шинжилгээ хийх үеэр агентлаг тус бүрт сургалтыг зохион байгуулсан. Нийт 12 удаагийн сургалтад 280 төрийн албан хаагч хамрагдсан байна. | 100 |
| НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС | | | | | | | | |
| СОЁЛ УРЛАГ | | | | | | | | |
| Зорилт | 1 | Иргэдийн дунд зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлнэ. | ОНТ 10.0 | Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо | 1934 | 2000 | Соёл, урлагийн салбарын 18 байгууллагаас цахим болон танхимын хэлбэрээр соён гэгээрүүлэх 2010 үйл ажиллагааг зохион байгуулсан. Тухайлбал, Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жил, Соёл, урлагийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жил, Номын баярын 91 дэх өдөр, Олон Улсын Музейн өдрүүдийг тохиолдуулан Соёл, урлагийн салбарын ажилчдын дунд "Хүний хөгжлийг дэмжих" арга зүйн сургалт, "Монгол бахархал", "Үндэсний бичиг соёл-номын өдөр", "С.Буяннэмэх 120 жил"-ийн ой зэрэг томоохон үйл явдлуудын хүрээнд арга хэмжээнүүдийг төлөвлөн зохион байгуулж, давхардсан тоогоор 5517 иргэнийг соён гэгээрүүлэх ажилд хамрууллаа. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|-------------|-----|---|---------|---|----|-----|---|-----|
| | | | | | | | Мөн нийт соёл урлагийн байгууллагууд нь өөрийн албан ёсны цахим хаягуудаар тогтмол мэдээллийг оруулж, 44599 хандалт авсан. | |
| Арга хэмжээ | 1.1 | Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн хүрээнд орон нутгийн түүх, өв соёлыг сурталчлах арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах | ОНТ 5.0 | Удирдлага, зохион байгуулалтаар хангасан арга хэмжээний тоо | 0 | 3 | Дундговь аймаг байгуулагдсаны 80 жил, Соёл, урлагийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жил, Номын баярын 91 дэх өдөр, Олон улсын Музейн өдрийг тохиоддуулан Соёл, урлагийн салбарын ажилчдын дунд зохион байгуулсан “Хүний хөгжлийг дэмжих” арга зүйн сургалт, Номын баярын хүрээнд 5, Музейн өдрийн хүрээнд 4 үйл ажиллагаа, “Нүүдэлчин Монгол-2022” соёлын биет бус өвийн их наадам, С.Буяннэмэхийн мэндэлсний 120 жилийн ой, Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн урлагийн үзлэг зэрэг 13 арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар 3 удаа хуралдан, удирдлага, арга зүйгээр хангаж, нийт 18 ажил, арга хэмжээг БШУГ, ТНС, Сайнцагаан сумтай хамтран зохион байгуулсан. | 100 |
| | 1.2 | Дундговь аймгийн түүхийн архивыг бүрдүүлэх | ОНТ 2.0 | Архив бүрдүүлэлтийн явцын хувь | 30 | 100 | Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Дуу хуурын өлгий Дундговь аймгийн түүхэн үүсэл хөгжил, өв соёл, ёс заншил, зан үйл, түүх, соёлын дурсгал болон дурсгалт газруудын талаар зохион байгуулсан онцлог үйл явдлуудаар аймгийн түүхийн архивыг бүрдүүлэх ажлыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулан ажилласан. Тухайлбал, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.350.000 төгрөгийн 4ТВ-ийн зөөврийн 3 хардыг авч, Үндэсний төв архиваас Дундговь аймагтай холбогдол бүхий нийт кино, дуу дүрсний 10, гэрэл зургийн 43, тогтоол шийдвэр 13-ыг хуулбарлан архив бүрдүүллээ. Мөн МҮОНТ-ээс “Монгол өв соёл” нэвтрүүлгийн 16 бичлэг, “Талын монгол” ТВ-ээс 24 бичлэг, “Лусын булаг” ХХК-ны “Уяхан замбуутивийн наран” урлагийн наадмын 11 бичлэг, “Анд студи”-ээс 10 бичлэг, Соёлын өвийн үндэсний төвөөс 7 бичлэг болон холбогдох зурагнууд хуулан авч архивт баяжилт хийсэн. Мөн аймгийн Засаг | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | |
|-----|--|--------------------------|---|---|-----|---|-----|
| | | | | | | даргын 2022 оны А/74 дугаар захирамжаар байгуулагдсан аймгийн ТСҮХД болон СББӨ-ийн улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгээр соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 123 хүний бичлэгийг хийж, аймгийн бүртгэл мэдээллийн санд бүртгэн авч, баяжилт хийсэн. Дундговь аймгийн түүхийн архивыг 100 хувь бүрдүүлэн төрийн архив руу шилжүүлэв. | |
| 1.3 | Алдарт уран зохиолч С.Буяаннэмэхийн мэндэлсний 120 жилийн ойг тусгай төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлэх | ОНТ 3.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Монгол Улсын Алдарт Гавьяат уран зохиолч С.Буяаннэмэхийн мэндэлсний 120 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг 2 бүлгийн хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталсан. Төлөвлөгөөний дагуу “Бидний мэдэх их зохиолч” аяныг өрнүүлэн, “Poetry night” яруу найргийн үдэш, нутгийн зохиолч яруу найрагчдын номын нээлтүүдийг хийж, “Алсыг зорьсон алтан загас” эсээ бичлэгийн уралдаан зохион байгуулсан. “Буяаннэмэхийн голомтын дөл” ном, С.Буяаннэмэхийн намтар, уран бүтээлийн III боть, Их зохиолчийг судалдаг судлаач, эрдэмтэд, сонирхогчдод зориулсан ном зүйн бүртгэлийг хэвлэн гаргасан. Аймгийн Музейд С.Буяаннэмэхийн амьдрал, уран бүтээлийг сурталчлах танхим байгуулж, олны хүртээл болгосон. Их зохиолчийн амьдрал, нийгэм улс төрийн түүхэнд бүтээсэн хөдөлмөр, гавьяаг харуулсан “Хуучир хуучилсан хууч” түүхэн, дуулалт жүжиг болон теле зохиомж шинээр бүтээж “С.Буяаннэмэх-120” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулснаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн. | 100 |
| 1.4 | Аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрут, хөтөлбөр гарган батлуулах | ОНТ 3.0 сая төгрөг | Маршрут, хөтөлбөр гарган батлуулсан эсэх /Тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | Дундговь аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн маршрутыг БОАЖГ-тай хамтран гаргалаа. Тус маршрутыг Улаанбаатар – Дундговь аймгийн Дэрэн сумын Хайлаастын ам /225 км/ – Их газрын чулуу /60 км/ – Ярх уул /35 км/ – Өөш манхан /150 км/ – Дэл уул /110 км/ – Цагаан суварга – /35 км/ – Хулд /75 км/ – Дэлгэрхангай /65 км/ – Онгийн хийд /90 км/ – Сангийн далай хийд /110 км/ – Сүм хөх бүрд /70 км/ – | 100 |

| | | | | | | | | |
|----------------------------|-----|---|------------|---|-------|-------|--|-----|
| | | | | | | | Бага газрын чулуу /18 км/ – Дэлгэрийн чойрын хийд /16 км/ – Дэлгэрцогт /24 км/ – Сайнцагаан сум – /40 км/ гэсэн 15 цэг дээр очихоор гаргасан бөгөөд тухайн дурсгалын танилцуулга хөтөлбөрийг гаргасан. | |
| БИЕИЙН ТАМИР, СПОРТ | | | | | | | | |
| Зорилт | 1 | Биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжиж, нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийг нэмэгдүүлнэ. | ОНТ 9.0 | Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо | 26058 | 26649 | Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан "Илүүдэл жингүй Эртэч монгол" аяны хүрээнд аймгийн хэмжээнд 15 сум, 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр 10-78 насны давхардсан тоогоор нийт 42268 иргэн нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1.1 | Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулах зөвлөгөө, удирдлагаар хангах | ОНТ 2.0 | Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн тоо | 10230 | 10230 | Өглөөний дасгал, алхалт, дугуй, бясалгал, хийн дасгал, зөөлөн гүйлт зэрэг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр нийт 22958 иргэн тогтмол хичээллэж байна. | 100 |
| | 1.2 | Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагт хамтран зохион байгуулах | ОНТ 5.0 | Хамтран зохион байгуулсан тэмцээний тоо | 0 | 1 | Аймгийн спортын 17 клуб, холбоодтой хамтран, улс, бүс, аймгийн аварга шалгаруулах, нэрэмжит зэрэг 80 гаруй уралдаан тэмцээнийг зохион байгуулсан. <ul style="list-style-type: none"> - Бадминтоны УАШТ, Жудо бөхийн насанд хүрэгчдийн Эрэгтэйчүүдийн 45 дахь удаагийн, - Эмэгтэйчүүдийн 30 дахь удаагийн УАШТ, - Ахмадын УАШ Шатрын тэмцээнийг Баянжаргалан сумын уугуул, Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч, Дэлхийн шатрын холбооны мастер, Олон Улсын Шатрын Холбооны мастер, Монгол Улсын 6 удаагийн аварга нэрт шатарчин Ж.Лхагваагийн нэрэмжит болгон, - Таекюондогийн өсвөр үе, залуучуудын УАШ 25 дахь удаагийн тэмцээн, - Волейбол, Хөнгөн атлетик зэрэг Улсын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 6 төрлөөр, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг - Сумо, Сагсан бөмбөг гэсэн спортын 2 төрлөөр аймаг орон нутагтаа Монголын спортын холбоодуудтай хамтран зохион байгуулсан. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|------------------|-----|---|-------------|------------------------------|------|------|--|-----|
| | 1.3 | Тив, дэлхий, олон улс, улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагчдад холбогдох журмын дагуу урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх | ОНТ 10.5 | Шийдвэрлүүлсэн тоо | 1 | 1 | Улсын аварга шалгаруулах урлаг, спортын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож, эхний гурван байранд шалгарсан 54 тамирчин, багш дасгалжуулагчдад 10,485,000 төгрөгийн урамшуулал олгож, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан. | 100 |
| БОЛОВСРОЛ | | | | | | | | |
| Зорилт | 1 | Боловсролын үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж, ЭЕШ-ын аймгийн дундаж оноог нэмэгдүүлнэ. | - | ЭЕШ-ын аймгийн дундаж оноо | 523 | 524 | БШУГ-ын Даргын баталсан хуваарийн дагуу 2 удаагийн сорилыг зохион байгуулж, 10 судлагдахууны сорилын даалгаврын гүйцэтгэлийг цахимаар танилцуулсан. Аймгийн Засаг даргын дэмжлэгээр хэрэгжүүлж байгаа Elab цахим сайтад БДБ олгож байгаа 8 сургуулийн 189 сурагчийн бүртгэлийг дахин сэргээн, тухайн сурагчдыг хариуцан ажиллах мэргэжлийн багш нарыг сайтад холбон ажиллуулсан. 2022 оны ЭЕШ-ын дундаж 509,59 оноотой шалгагдсан байна. | 50 |
| | | | | Хамран сургалтын дундаж хувь | 86.9 | 87.3 | 2021 оны жилийн эцсийн хүн амын тоотой харьцуулсан судалгаагаар Бага боловсролын хамран сургалт 94,3, суурь боловсролын хамран сургалт 96,1 байна. Аймгийн хэмжээний бага, суурь боловсролын хамран сургалтын дундаж хувь 95,1 хувь байна. emongolia системээс хаяг харьяалал татдаг болсонтой холбоотой хамран сургалтын хувь өмнөх жилүүдээс 3,7 хувь өссөн байна. | |
| Арга хэмжээ | 1.2 | Боловсролын салбарын төсөл хөтөлбөр, олон улсын хөрөнгө оруулалтын хүсэлт материалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх | - | Боловсруулсан төслийн тоо | 2 | 2 | Боловсролын салбарын төсөл хөтөлбөр, олон улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 5 настай болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, сургуулийн дотуур байрны сурагчдын авъяасыг хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр 3 төслийг боловсруулж холбогдох төслийн байгууллагуудад хүргүүлсэн байна. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | |
|-----|---|---------|--|---|---|--|-----|
| 1.3 | 12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах | ОНТ 3.0 | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 1 | 2 | <p>Аймгийн Ерөнхий боловсролын 8 сургуулиудын төгсөх ангийн сурагчид болон эцэг эх, асран хамгаалагч, мэргэжлийн болон анги удирдсан багш нартай төрийн өмчит 12 их сургуулийн төлөөллийг цахимаар уулзуулах “Дундговь боловсрол ехро-2022” арга хэмжээг 3 өдөр амжилттай зохион байгуулав. Тус арга хэмжээнд давхацсан тоогоор аймгийн мэргэжлийн 117 багш, 1119 төгсөгчид, 105 эцэг эх оролцон, ажил мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Аймгийн 9-12-р ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж, заавар зөвлөгөө өгч, гарын авлага тараан ажилласан. Үйл ажиллагаанд 375 сурагчдыг хамруулсан.</p> <p>Гадаадын их дээд сургуульд элсэн суралцах, мэргэжлээ хэрхэн сонгох мэдээлэл, лекц, ярилцлагыг 4 удаа явуулж, давхардсан тоогоор 9-12 дугаар ангийн 2000 сурагчдыг оролцуулан зохион байгууллаа.</p> | 100 |
| 1.4 | Өсвөр насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хувь хүний хөгжил сэдэвт сургалт зөвлөгөөнийг зохион байгуулах | ОНТ 5.0 | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 1 | 2 | <p>Хүмүүжлийн зэрэг арга модуль сургалтын хүрээнд “Эерэг аргаар харилцах” сургалт арга хэмжээнүүдийг зохион байгуулж 15 сумын 866 багш ажилтан, 2848 эцэг эх хамрагдаж 189 сурагч “Гар утасны зөв зохистой хэрэглээ”, “хорт зуршлаас татгалзах”, “сөрөг зан үйлээ өөрчлөх” зэрэг өөрийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан. Мөн дээрэлхэлт, үе тэнгийн дарамт, хувийн онцлог сэдвээр сургалтад 4955 хүүхдийг хамруулав.</p> | 100 |
| 1.5 | Сайн багш, сайн сургууль арга хэмжээг зохион байгуулах | ОНТ 6.0 | Зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо | 0 | 1 | <p>“Сайн багш, сайн сургууль” удирдамжийг 19 сургуулийн 500 гаруй багшид танилцуулж, 2 ажлын хэсэг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 12 сарын 05-ны хооронд аймгийн ЕБ-ын 19 сургуулийг 100 хувь хамруулан үнэлгээний ажлыг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд бага ангийн багш нарт МУБИС-тай хамтран 2 удаагийн 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангав.</p> | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|-----------------------------------|-----|--|-------------|-------------------------|----|------|---|------|
| | 1.6 | Дутагдалтай багшийн орон тоог нөхөж төгсөх курсын оюутантай гэрээ байгуулах | ОНТ 18.0 | Гэрээ хийсэн оюутны тоо | 3 | 5 | Аймгийн боловсролын салбарын 41 байгууллагаас 2022-2024 онд дутагдалтай байгаа багш нарын судалгааг авч нэгтгэн, ЕБС-иудад 2022 онд 50, 2023 онд-17, 2024 онд 17 мэргэжлийн багшийн дутагдал үүсэх судалгааг гараад байна. Ингэснээр МУБИС, МУИС-д суралцаж байгаа 1-4-р дамжааны нутгийн оюутнуудын судалгааг авч, МУБИС-ийн Оюутны албатай хамтран аймгийн харьяат 3-р дамжааны 9 оюутантай цахим уулзалт хийж, аймгийн 8 сургууль, цэцэрлэгийн удирдлагууд оролцон ажлын байрны саналыг хүргүүлэн ажиллаж, нийт 9 оюутантай гэрээ байгуулсан нь хүний нөөцийг бүрдүүлсэн арга хэмжээ болсон. Гэрээгээр төгсөж ирсэн оюутнууд Мандал, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумын сургуулиудад багшилж байна. | 100 |
| | 1.7 | UBT.mn цахим платформ нэвтрүүлэх | ОНТ 4.0 | Ашигласан сурагчдын тоо | 0 | 1000 | Дэлхийн банк, БШУЯ-наас хэрэгжүүлж буй Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр төслийн хүрээнд 5 дугаар ангийн 754 гаруй сурагчдын мэдлэг чадварыг үнэлэхэд UBT.mn цахим платформыг ашиглан 2 удаагийн сорилыг зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд сурагчид бие даан өөрийгөө сорих, багш нар цахимаар сурагчдаас сорил шалгалтыг зохион байгуулж ажлын ачаалал хөнгөвчлөгдсөн байна. | 75.4 |
| ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД | | | | | | | | |
| Зорилт | 1 | Хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр олон талт нөлөөллийн сургалт, үйл ажиллагааг нийт хүүхдийн 20 хувьд хүргэж үйлчилнэ. | | Хувь | 15 | 20 | Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр 8 төрлийн урьдчилан сэргийлэх, нөлөөлөл, хамгааллын хариу үйлчилгээг зохион байгуулж 9580 хүүхэд буюу нийт 16752 хүүхдийн 57.1%-д хүрч ажиллалаа. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|-------------|-----|--|---------|--|----|----|---|-----|
| Арга хэмжээ | 1.1 | Хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн сургалт арга хэмжээг зохион байгуулах | ОНТ 5,4 | Арга хэмжээний тоо | 6 | 8 | "Хүүхэд эрхэм хэрэглэгч" аян, "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр", "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулган", "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр", "Миний биеийн аюулгүйн дүрэм", "Нэгдүгээрт хүүхэд" нөлөөллийн аян, "Охидын эрхийг хамгаалах өдөр", Өсвөр насны хүүхдүүдийг хорт зуршил, цахим орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 8 төрлийн нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан 9580 хүүхэд, 7439 иргэн нийт 17019 хүүхэд, иргэд, хуулиар хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг хамрууллаа. | 100 |
| | 1.2 | Хүүхдийн осол гэмтэл, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөлөл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | ОНТ 0,2 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 2 | Хүүхдийг осол гэмтэл, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хүүхдэдээ тавих хараа хяналт, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийтэд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилгоор "Аюулгүй хүүхдийн орчин", "Нэг дүгээрт шалга" 2 төрлийн хяналт шалгалт, Өсвөр насны хүүхдүүдийг хорт зуршил, цахим орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 14 хоногийн аяныг зохион байгуулж байгууллагын цахим хаягаар 10 төрлийн постер, 1 цахим сэтгүүлийг байршуулан 3528 иргэдийн хандалт авч, 2140 сурагчид "Цахим орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь", "Электрон тамхины хор нөлөө" сургалтыг зохион байгууллаа. | 100 |
| | 1.3 | Хүүхдийн нас сэтгэхүй, бие бялдар, эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр ТББ, Холбоодуудтай хамтарч ажиллах | ОНТ 4,3 | Хамтарч ажилласан ТББ, Холбоод, Клубын тоо | 0 | 4 | Хүүхдийн, хөгжил хамгааллыг дэмжих чиглэлээр Монголын эмэгтэйчүүдийн холбооны Дундговь дахь салбар, Гэрэлтдэг ертөнц ТББ, Дүүрэн билэг НҮТББ, Илтгэгч Н.Ганбилэг нартай хамтран ажиллах ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, нийт 6 төрлийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Гэрээний биелэлт 100%-тай байна. Тус үйл ажиллагаанд нийт 4,286,400 төгрөгийн төсөв зарцууллаа. | 100 |
| Зорилт | 2 | Цахим орчноор дамжуулан Залуучуудын хөгжлийн оролцооны хувийг 2021 онд 30 хувь байсныг 2022 онд 35 хувьд хүргэнэ. | ОНТ 4,2 | Залуучуудын оролцооны хувь | 30 | 35 | Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан 11 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, контент бэлтгэн 2022 онд 5467 залуучууд буюу нийт залуучуудын 37,7%-ийг хамруулж ажиллалаа. Тус үйл ажиллагаанд 8,5 сая төгрөг төлөвлөн баталснаас 4190252 төгрөг зарцууллаа. | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|-------------|--|---|-----------------------------------|--|---|--|--|-----|
| Арга хэмжээ | 2.1 | Цахим орчноор дамжуулан Залуучуудад сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах | ОНТ 1,5 | Үйл ажиллагааны тоо | 6 | 8 | -Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аян, “Мөнгөний 7 хоног-2022”, “Өсвөрийн парламент” өглөөний цайтай сургалт, “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо манлайлал” сургалт, амьдрах ухааны 12 модуль сургалт зэрэг 5 төрлийн сургалтыг 1764-н өсвөр үе, залуучуудыг хамруулан зохион байгууллаа. Мөн Залуучуудын хэрэгцээ, сонирхолд тулгуурлан Дундговь аймгийн Монгол банкттай хамтран “Хуримтлал ба мөнгөний менежмент”, “Мөнгөө зөв удирдаж, ирээдүйн санхүүгийн эрх чөлөөнд хүрэх алхам” сэдэвт 2 подкаст, лайв нэвтрүүлэг 4, 2 төрлийн цахим сургалтыг, пэйж хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэлээ. | 100 |
| | 2.2 | Залуучуудын хөгжлийн чиглэлээр улсад тэргүүлэгч аймаг болон дүүрэгтэй шифийн харилцаа тогтоож хамтарч ажиллах | УТХО 6,7 | Туршлага солилцсон аймаг, дүүргийн тоо | 0 | 1 | Дундговь аймаг 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх, хүүхдийн асуудлаар ажилладаг ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ЗГХА, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Налайх дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн үйл ажиллагаатай тус тус туршлага солилцох арга хэмжээг зохион байгууллаа. Туршлага солилцох 3 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 62 мэргэжилтнийг хамруулж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр баримталж буй бодлого, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх санал солилцож, зөвлөгөө мэдээллийг авч ажиллалаа. | 100 |
| | | | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 0 | 1 | | |
| 2.3 | Залуучуудад тулгарах асуудал, бэрхшээлийг даван туулах чадамж, залуучуудын бие бялдар оюун санаа сэтгэлгээ, ур чадварын харилцаанд ахиц өөрчлөлт өгөх цогц арга хэмжээг зохион байгуулах | УТХО 2,6 | Арга хэмжээ зохион байгуулсан тоо | 0 | 2 | - “Family day” Гэр бүлийн өдөрлөг арга хэмжээг 4 гэр бүлийн 18 гишүүдийг хамруулан зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр гэр бүлүүд өөрсдийн ижилсэх фудволкон дээр зураг зурж, аавуудын дунд “Эхнэрээ хэр сайн мэдэх вэ?” хөгжөөнт тоглоомыг тоглон дурсамж дүүрэн өнгөрүүллээ. - Өсвөр үеийн залуус мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг | 100 | |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|----------------|-----|---|-------------|---|----|----|---|-----|
| | | | | | | | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас санаачлан "Шинэ Түүх - New Story" хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны ерөнхий газар, Соёл, урлагийн газар болон Монголын залуучуудын холбоотой хамтран улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Ирээдүйн эзэд" мэргэжил сонголтын аян зохион байгуулагдаж ЕБС-иудын 9,10,11 дүгээр ангийн 700 сурагч хамрагдсан. | |
| Зорилт | 3 | Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр олон талт нөлөөллийн ажил, сургалт, зөвлөгөөнийг нийт гэр бүлийн 10 хувьд хүргэж үйлчилнэ. | УТХО 9.9 | Хүрч үйлчилсэн гэр бүлийн хувь | 10 | 20 | Гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлага, оролцоог хангах, харилцааны тогтвортой байдлыг дэмжих зорилгоор гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 18 чиглэлийн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, нийт гэр бүлийн 36 хувь буюу 5346 гэр бүлд хүргэж ажиллалаа. | 100 |
| | 3.1 | Гэр бүлд боловсрол олгох олон талт сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | УТХО 2,8 | Сургалт нөлөөллийн үйл ажиллагааны тоо | 4 | 8 | Гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцааны тогтвортой байдлыг дэмжих, иргэд олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох зорилгоор 8 төрлийн модуль сургалтыг цахимаар 3195, танхимаар 2272 иргэнд зохион байгуулж, нийт гэр бүлийн 36 хувь буюу 5346 гэр бүлд хүргэж ажиллалаа. | 100 |
| Арга хэмжээ | 3.2 | Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн зөвлөгөөн зохион байгуулах | ОНТ 6.5 | Зөвлөгөөн зохион байгуулсан эсэх /Тийм-1, үгүй-0/ | 0 | 1 | Дундговь аймаг 2022 оныг "Хүний хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх "ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ"-ийн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн гишүүд, Байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн 205 төлөөлөгч оролцож, хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх хамгаалах, хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хүндтэтгэн сонсож, шийдвэр гаргах, гэр бүлийн боловсрол олгох, эцэг эхчүүдэд хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг ойлгуулах, эцэг эхийн зөвлөлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд хамгааллын бодлого, гэр бүл хүүхэд рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр зөвлөмж | 100 |

| | | | | | | | боловсруулж гаргалаа. | |
|-------------------------|--|--|-------|---|------|----|--|-----|
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | | |
| Зорилт | 1 | Эрүүл мэнд, хүн ам зүйн талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх. | - | Арга зүйгээр хангаж, хяналт тавьсан тоо | 2 | 2 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд 3 удаа хяналт тавьж, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав. | 100 |
| -Арга хэмжээ | 1.1 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн барилгыг үе шаттай шинээр барих, их засвар, өргөтгөл хийх ажилд хяналт тавих | - | Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн эсэх /Тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Өндөршил, Луус, Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр бариулахаар хөрөнгийн төсвийг гарган 2023 оны төсөвт тусгуулахаар холбогдох газруудад хүргүүлээд байна. | 50 |
| | | | | Хяналт тавьсан тоо | 2 | 2 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилгын явцад 6 болон 11 сард хяналт тавихад, гүйцэтгэл 96,0 хувьтай байна. | |
| | 1.2 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд, багийн эмч нарын унааны парк шинэчлэлтийг үе шаттай хийж, түргэн тусламжийн автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглоход дэмжлэг үзүүлэх | 192.0 | Автомашины хангалтын хувь | 92,0 | 93 | Түргэн тусламжийн автомашин дутагдалтай байсан Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 44,9 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Фургон автомашин шинээр олгогдсон. Автомашины хангалтын хувь 93,0 хувьтай байна. | 100 |
| | Төноглогдсон түргэн тусламжийн авто машины тоо | 1 | 2 | Дэлгэрхангай, Баянжаргалан Эрдэнэдалай сумдын эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг 15,2 сая төгрөгний тоног төхөөрөмжөөр тоноглолоо. | | | | |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | |
|-----|---|--------------|--|------|------|--|-----|
| 1.3 | Явуулын тусламж, үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх | - | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн хамрагдалтын хувь | 30,4 | 32,5 | Улаанбаатар хотын Лев-Мед ХХК-тай хамтран Хулд, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад дотор, эмэгтэйчүүд, ЭХО, уушги харшил, зүрх судасны цахилгаан бичлэг, оношилгоог алслагдсан сумын 3344 иргэдэд явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүллээ. Нийт үзүүлсэн иргэдийн 62 хувь нь ковидын дараах хам шинж, 29 хувь нь амьсгалын замын үрэвсэл, 10,1 хувь нь тоосны харшил, 9,7 хувь нь арьсны харшил, 32,5 хувь нь даралт ихсэх, 20,0 хувь нь цээжний бах, 23,9 хувь нь бөөрний үрэвсэл, 21,9 хувь нь нойр булчирхайн үрэвсэл, 19,67 хувь нь ходоодны архаг үрэвсэл тус тус оношлогдсон байна. Бөөрний хавдар 3-ийг илрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээлээ. Аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 34,2 байна. | 100 |
| 1.4 | Алсын зайн оношлогоо, зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлж эмч нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангахад хамтран ажиллах | УТХО 34,0 | Компьютерийн тоо | 61 | 3 | Мобайль технологээр хангах үйл ажиллагааны хүрээнд Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сайхан-овоо, Өлзийт сумдын эрүүл мэндийн төвүүдэд 60,0 сая төгрөгний төсөвтэйгөөр төрийн худалдан авах газарт тендер зарлагдаж байна. Эрүүл мэндийн газар, 15 сумын эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 34 сая төгрөгний үнэ бүхий 1 суурин компьютер, 15 зөөврийн компьютерээр хангагдсан. | 100 |
| 1.5 | Эрүүл мэндэд ээлтэй сум, баг, байгууллага болох хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, ээлтэй сум, баг, байгууллагыг шалгаруулах ажилд дэмжлэг үзүүлэх | | Дэмжлэг үзүүлсэн тоо | 0 | 1 | 2022 онд "Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Эрчүүдээ хайрлая", "Давсны хэрэглээгээ багасгая", "Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус", "Архи, тамхи хорт зуршлаас татгалзъя" зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт 36670 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 25 удаа сургалт зохион байгуулж, "Илүүдэл жингүй Эртэч Монгол" 3 сарын аян, "Зөвийг хэвшүүлье" 45 хоногийн аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн 37679 иргэнийг хамруулан, мэдээлэл сургалт сурталчилгааг нийт хүн амын 82.3 хувьд хүргэлээ. "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага", шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийн дагуу 2 материал ирүүлж, үнэлгээ хийж шалгарууллаа. Ингэснээр Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 38 болж | 100 |

| | | | | | | | | |
|-------------------------------------|-----|--|---------------|--|------|------|---|------|
| | | | | | | | нэмэгдэв. | |
| | 1.6 | Хүн амын эрэлт хэрэгцээ, салбарын бодлогод нийцүүлэн Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулан ажиллах. | | Тусгай зөвшөөрөл сунгаж, шинээр олгосон ААН-ийн тоо | 22 | 12 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс нь 3 удаа хуралдаж, журмын дагуу 4 аж ахуй нэгжид шинээр тусгай зөвшөөрөл олгож, 8 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгалаа. | 100 |
| | 1.7 | Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. | | Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоо | 1150 | 1500 | Ажил олгогчид нь өөрсдийн ажилтнуудыг үзлэгт хамруулах хүрээнд 47 байгууллагын 963 ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан давхардсан тоогоор 1926 үзлэг шинжилгээ хийж 601 өвчлөл илэрсэн бөгөөд Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл зонхилж байгаа бөгөөд нийт үзлэгт хамрагдсан иргэдийн 85.0 хувьд эрхтэн тогтолцооны эмгэг илэрсэн байна. Өвчлөл илэрсэн иргэдийг хяналтад авч 3 дахь шатлалын эмнэлэгт 4 иргэнийг шилжүүлэн эмчилсэн. Эрүүлжилтийн хувь 61,4 байна. | 64.2 |
| | 1.8 | Орон нутгийн Улаан Загалмайн салбар хороотой батлагдсан төлөвлөгөөний хүрээнд хамтран ажиллах | ОНХС 20.0 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 85 | Орон нутгийн Улаан Загалмайн салбар хороотой 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөж ажилласнаас хэрэгжилт 70 хувьтай байна. | 70 |
| ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ | | | | | | | | |
| Зорилт | 1 | Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх | ОНТ 26.2 | Дэмжлэг үзүүлсэн тоо | 2 | 3 | Өмнөговь аймагт болсон ХБИ-ийн тусгай олимп арга хэмжээнд 25 хүн хамруулсан ба унааны зардалд 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. ХБИ 65 хүүхдэд 3,250,000 төгрөгийн хөрөнгө зарцуулж хүндэтгэл үзүүлсэн. ХБИ-ийн чуулган зохион байгуулж 7,3 сая төгрөг зарцууллаа. Олон улсын ахмадын баяраар "Ахмадаа дээдэлъе" арга хэмжээ зохион байгуулж, 14,7 сая төгрөг зарцууллаа. | 100 |
| Арга хэмжээ | 1.1 | 90-ээс дээш настай ахмад настнуудад аймгийн Засаг даргын хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах | ОНТ 11,0 | Нэрсийг статистикаас шүүж тулган, сумдад тараах ажлыг хийх тоо | 1 | 1 | Аймгийн 90-ээс дээш настай 126 ахмад настнуудын нэрсийг аймгийн Статистикийн хэлтсээс гаргуулан авч сумдын нэрстэй тулгалт хийж, Засаг даргын хүндэтгэл үзүүлж, 11,043,000 төгрөг зарцуулсан. | 100 |
| | 1.2 | Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь | | Хяналт тавьж, зөвлөн | 12 | 24 | Сум, агентлагийн удирдлагуудад ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан | 100 |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | |
|---------------------|--|------------|---|---|----|---|-----|
| | ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх заалтыг сум, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих | | тусалсан сум, байгууллагын тоо | | | сэргийлэх чиглэлээрх заалтыг сум, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгаж ажиллахыг сургалтаар тайлбарлан чиглэл болгосон ба 22 агентлаг 5 сум дотоод журамдаа өөрчлөлт оруулан, эргэж хянуулан ажиллаж байна. | |
| 1.3 | ХАБЭА-ын аяныг зохион байгуулах, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлэх | ОНТ 1,3 | Сарын аяны төлөвлөгөө гарган зохион байгуулах тоо | 1 | 1 | ХАБЭА-ын аяныг 4 сарын 1-нээс 1 сарын хугацаанд зохион байгуулж, 10 ажил төлөвлөн 87,3 хувийн хэрэгжилттэй тайланг хугацаанд нь гаргаж ХАБЭМТөвд хүргүүллээ. | 100 |
| 1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэмлэх олгох, цахимжуулах | - | Материалын бүрдлийн дагуу үнэмлэхийн бичилт хийж бүртгэлжүүлсэн эсэх /Тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэмлэх олгох ажлыг цахимжуулах бэлтгэл ажил хийгдэж байна. ХБИ үнэмлэх олгохдоо холбогдох материалыг авч бүртгэл хөтөлж байна. Нийт 178 иргэнд үнэмлэх олгосон. | 100 |
| 1.5 | Ахмад настанд ээлтэй, сум, байгууллагыг жил бүр шалгаруулах | 4,4 ОНТ | Ахмадын байгууллагатай хамтран ажиллах тоо | 1 | 1 | Аймгийн хэмжээнд Ахмадад ээлтэй сум-6, баг-2, байгууллага-24 нийт 32 болсон. 2021 оны шилдгүүдийг 2022 оны эхний улиралд шалгарууллаа. Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага шалгаруулах ажилд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 100 |
| 1.7 | Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтыг Мерит төсөлтэй хамтран зохион байгуулах | 2,0 ОНТ | Сургалтад хамрагдах албан хаагчдын тоо | 1 | 20 | Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтыг Мерит төсөлтэй хамтран зохион байгуулж байна. Цахим сургалтад нийт 200 гаруй төрийн албан хаагчид хамрагдаад байна. Танхимын сургалтад 30 албан хаагч хамрагдаж, 9 бичил төсөл хэрэгжүүлж ажиллалаа. | 100 |
| ЦЭРГИЙН ШТАБ | | | | | | | |

ДУНДГОВЬ АЙМАГ

| | | | | | | | | |
|-------------|---|---|---|--|----|----|---|-----|
| Зорилт | 1 | “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ. | ОНТ 5.0 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 88 | 90 | “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ын 14 арга хэмжээг 100% хэрэгжүүлсэн ба хөтөлбөрийн хүрээнд аймгийн 11 сумын ахлах ангийн 1579 сурагчдад сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа. | 100 |
| Арга хэмжээ | 1.1 | Аймгийн Засаг даргын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн дунд зохиогдох Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 1 | Аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг Дундговь аймгийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Нэгдүгээр үе шатанд: Ерөнхий боловсролын сургуулиуд сургуулийн аваргаа шалгаруулав. Хоёрдугаар үе шатанд: ЕБС-ын 6 сургуулийн 5 тасаг хурд, хүч, авхаалж, самбаагаа сорьж оролцсон. | 100 |
| | 1.2 | “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймгийн хэмжээнд сурталчлах ажлыг ЗДТГ-ын Цэргийн штаб, БСУГ-тай хамтран зохион байгуулна. /Хөтөлбөрийн хүрээнд/ | - | Хамрагдалтын хувь | 0 | 75 | “Монгол бахархлын өдөр”-ийг тэмдэглэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд Батлан хамгаалахын сайд Дундговь аймгийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээ 3-ийн Ажил, үйлчилгээ-1. 1.6 дахь заалтын дагуу тус тус амжилттай зохион байгууллаа. Цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах ёслолд 18 нас хүрсэн цэргийн насны залуучуудад цэргийн үүрэгтний үнэмлэхийг 38-н иргэнд гардуулж төлөвлөгөөт арга хэмжээ 80 хувь биелэгдсэн. | 100 |
| Үнэлгээ | Зорилтын тоо-40 Арга хэмжээний тоо 145 | | Зорилтын хэрэгжилтийн дундаж – 87,9% Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж- 95,4% | | | | | |


ХЭРЭГЖИЛТИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  Н.ДЭЛГЭРМАА

2023 оны 02 сарын 24 өдөр